



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

АКТ

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IY байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.03.25 № 09/69 УАГ-САГ/2013/05-СТТА-ТӨУГ

ЗӨРЧЛИЙГ АРИЛГАХ ТУХАЙ

Үндэсний аудитын газрын 2013 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу “Дулаан шарын гол” ТӨХК-ий 2012 оны санхүүгийн тайланд аудит хийх явцад хувь Хувь хүний орлогын албан татвар 6,908.9, НӨАТ 6,141.9 нийт 13,050.8 мянган төгрөгийн татварыг төсөвт төлөөгүйд ногдох торгууль 6,630.7 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй зөрчил илэрлээ.

Энэ нь дараах хуулийн заалтыг зөрчсөн байна.

- Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 27.1.4-д “энэ хуулийн 12-р зүйл, 13.1.15,14.1.2,14.1.3-т заасан орлогод энэ хуулийн 23.1-д заасан хувиар тооцон улирал тутам албан татвар ногдуулан дараа улирлын эхний сарын 15-ны өдрийн дотор төлөх” тухай заалт, 74.2-т татварыг хугацаанд төлөөгүй бол төлөгдөөгүй татварын дүнд хугацаа хэтэрсэн хоног тутам 0,1%-тай тэнцэх хэмжээний торгууль ногдуулна”,
- НӨАТ тухай хуулийн 17.1.1-д “нөхөн төлбөл зохих НӨАТ-ын нийт дүнгээс 0,3 хувиар хүү төлүүлэх”,
- Засгийн газрын 2011 оны 05-р тогтоолоор 0,047 %-иар алданги тооцох”.

Дээрх хуулийн заалтуудын дагуу торгууль тооцоход төлөх татварын үнийн дүнгийн 50 хувиас хэтэрч байгаа тул Татварын ерөнхий хуулийн 74.3-д “74.1,74.2-д заасны дагуу нөхөн төлүүлэх болон хугацаанд нь төлөөгүй татварт алданги тооцох бөгөөд уг алдангийн хэмжээ нөхөн төлүүлэх татварын үнийн дүнгийн 50 хувиас хэтрэхгүй байна.” гэсэн заалт болон Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих...” гэж заасныг үндэслэн **АКТ ТОГТООХ НЬ:**

1. Төлвөл зохих татварын дүнгийн 50 хувиар тооцсон торгууль 6,630.7 мянган төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Улсын төсвийн орлогын 900000601 дугаар дансанд 2013 оны 5 дугаар сарын 1-ний дотор төвлөрүүлэх,
2. Тогтоосон актын төлбөрийг барагдуулах ажлыг “Дулаан Шарын гол” ТӨХК-ий захирал Б.Энхцэцэг, ерөнхий нягтлан бодогч П.Сүнжидмаа нарт хариуцуулав.
3. Актын биелэлтийг гаргаж, 2013 оны 5 дугаар сарын 15-ны дотор УАГ-т ирүүлэх.

АКТЫГ

ТОГТООСОН:

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
АХЛАХ АУДИТОР

М.СЭВЖИДМАА
“СИ ЭС АЙ АУДИТ” ХХК-ИЙ
ЗАХИРАЛ
М.СЭВЖИДМАА

ЗӨВШӨӨРСӨН:

“ДУЛААН ШАРЫН ГОЛ” ТӨХК-ИЙ
ЗАХИРАЛ
Б.ЭНХЦЭЦЭГ
“ДУЛААН ШАРЫН ГОЛ” ТӨХК-ИЙ
ЕРӨНХИЙ НИЯГТЛАН БОДОГЧ
П.СҮНЖИДМАА